



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/33

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.1 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэх хэсэг 4.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 79, 80 дугаар тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 16 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

"МХБ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн  
А/33 дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах  
арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны компаниуд**

1. "Асе энд т капитал ҮЦК" ХХК
2. "Тэнгэр капитал ҮЦК" ХХК
3. "Монсек ҮЦК" ХХК
4. "Блүмсбюри секьюритиес ҮЦК" ХХК
5. "Эм ай би жи ХХК ҮЦК"
6. "Эф си икс ҮЦК" ХХК
7. "Эм ай си си ҮЦК" ХХК
8. "Блюскай секьюритиз ҮЦК" ХК
9. "Гацуурт трейд ҮЦК" ХХК
10. "Батс ҮЦК" ХХК
11. "Зэт жи би ҮЦК" ХХК
12. "Өндөрхаан инвест ҮЦК" ХХК
13. "Масдак үнэт цаасны компани" ХХК
14. "Аргай бэст ҮЦК" ХХК
15. "Алтан хоромсог ҮЦК" ХХК
16. "Блэкстоун интернэйшнл ҮЦК" ХХК

---oOo---